



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн  
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/27/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: Ц.Бадрал

Утас: 91983443

цахим хаяг: Badralts@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

**ХОВД АЙМГИЙН ТАТВАРЫН  
ХЭЛТСИЙН ДАРГА Х.БАТЦЭЦЭГ  
ТАНАА**

2023.02.08. № 02/16  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### **Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### **Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Үндсэн хөрөнгөтэй холбоотой 2.4 сая төгрөгийн биетээр оршин байхгүй хөрөнгийн асуудал шийдвэрлэгдээгүй он дамжин байсаар байна.

### **Аудитын гол асуудал**

Тайлант хугацаанд 30.0 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг орон нутгийн санхүүжилтээр, 27.7 сая төгрөгийн компьютерыг Татварын ерөнхий газраас хүлээн авч бүртгэжээ.

### **Бусад асуудлын хэсэг**

2022 онд тус хэлтэс нь татварын орлогыг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж улсын төсөвт 3,893.5 сая төгрөг төвлөрүүлэхээс 4,597.1 сая төгрөг төвлөрүүлж, 118.1%, аймгийн төсөвт 5,647.2 сая төгрөг төвлөрүүлэхээс 13,372.4 сая төгрөг төвлөрүүлж, 236.8%, сумын төсөвт 16,532.6 сая төгрөг төвлөрүүлэхээс 15,991.1 сая төгрөг төвлөрүүлж 96.7%, нийт дүнгээр төлөвлөгөөний биелэлт 30.3%-иар давуулан биелүүлсэн байна.

Тус байгууллага нь тайлант онд 5 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, гүйцэтгэлийг гарган Татварын ерөнхий газарт дүгнүүлэхээр хүргүүлсэн байна.

021020140

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>88,875,121.93</b>	<b>87,565,841.93</b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>88,875,121.93</b>	<b>87,565,841.93</b>
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>88,875,121.93</b>	<b>87,565,841.93</b>
35410	Бичиг хэргийн материал	5,140,640.00	4,558,760.00
35430	Сэлбэг хэрэгсэл	2,600,000.00	2,600,000.00
35440	Түлш, шатах тослох материал	1,550.00	21,570.00
35470	Бусад хангамжийн материал	81,132,931.93	80,385,511.93
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>1,492,608,603.35</b>	<b>1,421,495,921.98</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>1,492,608,603.35</b>	<b>1,421,495,921.98</b>
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>1,458,729,603.35</b>	<b>1,387,616,921.98</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,392,429,000.00	1,392,429,000.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-110,185,998.25	-145,374,352.50
39203	Авто-тээврийн хэрэгсэл	115,000,000.00	115,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-56,922,897.50	-76,072,075.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	228,086,938.76	285,514,189.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	-125,769,083.84	-198,104,943.90
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,877,100.00	17,877,100.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-7,772,327.60	-9,484,277.12
39214	Бусад үндсэн хөрөнгө	130,567,700.00	130,567,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-124,580,828.22	-124,735,419.30
393	Биет бус хөрөнгө	33,879,000.00	33,879,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	33,879,000.00	33,879,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,581,483,725.28</b>	<b>1,509,061,763.91</b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,581,483,725.28</b>	<b>1,509,061,763.91</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,581,483,725.28</b>	<b>1,509,061,763.91</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	356,656,848.00	356,656,848.00
51101	Өмч: - төрийн	356,656,848.00	356,656,848.00
512	Хуримтлагдсан үр дүн	1,213,718,541.99	1,141,296,580.62
51210	Өмнөх үеийн үр дүн	1,273,011,896.06	1,213,718,541.99
51220	Тайлант үеийн үр дүн	-59,293,354.07	-72,421,961.37
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	11,108,335.29	11,108,335.29
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,581,483,725.28</b>	<b>1,509,061,763.91</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Балансын зүйл	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,046,788,540.00</b>	<b>1,165,304,730.42</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>46,875,740.00</b>	<b>37,286,730.42</b>
120	Нийтлэг татварын бус орлого	46,875,740.00	37,286,730.42
120009	Бусад орлого	27,894,240.00	35,000.00
120010	Борлуулалтын орлого (цэвэр) /ТӨҮГ/	18,981,500.00	37,251,730.42
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>999,912,800.00</b>	<b>1,128,018,000.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	998,412,800.00	1,093,018,000.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	998,412,800.00	1,093,018,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,500,000.00	35,000,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,500,000.00	35,000,000.00

<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,106,081,894.07</b>	<b>1,237,726,691.79</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,106,081,894.07</b>	<b>1,237,726,691.79</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,102,081,894.07</b>	<b>1,211,613,665.01</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>742,360,800.00</b>	<b>807,640,560.90</b>
210101	Үндсэн цалин	451,863,323.35	485,208,874.87
210102	Нэмэгдэл цалин	111,444,076.00	129,806,271.43
210103	Унаа хоолны хөнгөлөлт	97,988,185.65	97,262,240.00
210104	Урамшуулал	81,065,215.00	95,363,174.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>100,197,700.00</b>	<b>102,314,612.32</b>
210201	Тэтгэврийн даатгал	69,467,556.00	68,052,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	8,113,645.00	8,006,200.00
210203	ҮОМШ өвчний даатгал	5,945,893.00	8,642,012.32
210204	Ажилгүйдлийн даатгал	1,486,477.00	1,601,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,184,129.00	16,012,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,788,800.00</b>	<b>52,198,800.00</b>
210301	Гэрэл цахилгаан	3,078,692.00	3,257,025.00
210302	Түлш, халаалт	42,151,400.00	42,151,400.00
210303	Цэвэр, бохир ус	4,558,708.00	6,790,375.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>24,095,905.00</b>	<b>34,932,243.58</b>
210401	Бичиг хэрэг	6,516,000.00	8,678,493.58
210402	Тээвэр шатахуун	7,742,000.00	7,776,180.00
210403	Шуудан холбоо, интернэтийн төлбөр	3,562,200.00	3,376,550.00
210404	Ном, хэвлэл	333,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,160,900.00	325,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,781,005.00	3,769,900.00
210408	Бараа материал акталсны зардал	0.00	11,006,020.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>0.00</b>	<b>2,323,200.00</b>
210604	Урсгал засвар	0.00	2,323,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>5,692,000.00</b>	<b>2,474,900.00</b>
210702	Дотоод албан томилолт	5,692,000.00	2,474,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>55,068,600.00</b>	<b>78,399,600.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	51,982,100.00	72,211,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	896,000.00	753,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,400.00	102,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,990,000.00	0.00
210807	Газрын төлбөр	76,100.00	311,000.00
210810	Борлуулалт, маркетингийн зардал /ТӨҮГ/	0.00	5,000,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>124,878,089.07</b>	<b>131,329,748.21</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,540,000.00	2,789,815.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал	119,338,089.07	128,539,932.41
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,000,000.00</b>	<b>26,113,026.78</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,000,000.00	25,369,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	25,369,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>743,526.78</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	743,526.78
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-59,293,354.07</b>	<b>-72,421,961.37</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-59,293,354.07</b>	<b>-72,421,961.37</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
<b>0</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>999,912,800.00</b>	<b>1,128,053,000.00</b>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	0.00	35,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	0.00	35,000.00
120009	Бусад орлого	0.00	35,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>999,912,800.00</b>	<b>1,128,018,000.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>998,412,800.00</b>	<b>1,093,018,000.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	998,412,800.00	1,093,018,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>1,500,000.00</b>	<b>35,000,000.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,500,000.00	35,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>999,912,800.00</b>	<b>1,098,053,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>999,912,800.00</b>	<b>1,098,053,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>995,912,800.00</b>	<b>1,071,939,973.22</b>
<b>2101</b>	<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>742,360,800.00</b>	<b>809,877,573.22</b>
210101	Үндсэн цалин	422,018,288.20	487,445,887.19
210102	Нэмэгдэл	153,735,919.00	129,806,271.43
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	71,362,092.80	97,262,240.00
210104	Урамшуулал	95,244,500.00	95,363,174.60
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>100,197,700.00</b>	<b>100,077,600.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	70,503,300.00	68,052,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,423,600.00	8,006,200.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,938,900.00	6,405,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,484,700.00	1,601,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	14,847,200.00	16,012,400.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,788,800.00</b>	<b>52,198,800.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	3,078,692.00	3,257,025.00
210302	Түлш, халаалт	42,151,400.00	42,151,400.00
210303	Цэвэр, бохир ус	4,558,708.00	6,790,375.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>26,814,900.00</b>	<b>23,050,300.00</b>
210401	Бичиг хэрэг	6,516,000.00	4,543,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,742,000.00	7,796,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,562,200.00	3,852,800.00
210404	Ном, хэвлэл	333,800.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,160,900.00	325,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7,500,000.00	6,532,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>4,400,000.00</b>	<b>2,434,500.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,000,000.00	0.00
210604	Урсгал засвар	3,400,000.00	2,434,500.00
2107	Томилолт, зочны зардал	5,692,000.00	2,474,900.00
210702	Дотоод албан томилолт	5,692,000.00	2,474,900.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>59,378,600.00</b>	<b>78,399,600.00</b>

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	53,282,100.00	77,211,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	896,000.00	753,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	102,400.00	102,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	22,000.00	22,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,000,000.00	0.00
210807	Газрын төлбөр	76,100.00	311,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>7,280,000.00</b>	<b>3,426,700.00</b>
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,280,000.00	3,426,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,000,000.00</b>	<b>26,113,026.78</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,000,000.00</b>	<b>25,369,500.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	25,369,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,000,000.00	0.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>0.00</b>	<b>743,526.78</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.00	743,526.78
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>0.00</b>	<b>30,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>0.00</b>	<b>30,000,000.00</b>
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	30,000,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	30,000,000.00
222001	Тоног төхөөрөмж	0.00	30,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>0.00</b>	<b>-30,000,000.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	1,273,011,896.06	1,640,777,079.35
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	1,273,011,896.06	1,640,777,079.35
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-59,293,354.07	-59,293,354.07
2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	1,213,718,541.99	1,581,483,725.28
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	1,213,718,541.99	1,581,483,725.28
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-72,421,961.37	-72,421,961.37
2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	356,656,848.00	11,108,335.29	1,141,296,580.62	1,509,061,763.91

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Бүртгэлийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>1,093,018,000.00</b>	<b>1,092,274,473.22</b>	<b>743,526.78</b>	<b>99.93</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>1,093,018,000.00</b>	<b>1,092,274,473.22</b>	<b>743,526.78</b>	<b>99.93</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>1,067,648,500.00</b>	<b>1,066,904,973.22</b>	<b>743,526.78</b>	<b>99.93</b>
<b>Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил</b>		<b>810,621,100.00</b>	<b>809,877,573.22</b>	<b>743,526.78</b>	<b>99.91</b>
Үндсэн цалин	21010100	483,072,400.00	487,445,887.19	-4,373,487.19	100.91
Нэмэгдэл цалин	21010200	156,251,100.00	129,806,271.43	26,444,828.57	83.08
Унаа хоолны Хөнгөлөлт	21010300	74,052,000.00	97,262,240.00	23,210,240.00	131.34
Урамшуулал	21010400	97,245,600.00	95,363,174.60	1,882,425.40	98.06
<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>		<b>100,077,600.00</b>	<b>100,077,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Тэтгэврийн даатгал	21020100	68,052,800.00	68,052,800.00	0.00	100.00
Тэтгэмжийн даатгал	21020200	8,006,200.00	8,006,200.00	0.00	100.00
ҮОМШӨ-ний даатгал	21020300	6,405,000.00	6,405,000.00	0.00	100.00
Ажилгүйдлийн даатгал	21020400	1,601,200.00	1,601,200.00	0.00	100.00
Эрүүл мэндийн даатгал	21020500	16,012,400.00	16,012,400.00	0.00	100.00
<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>		<b>52,198,800.00</b>	<b>52,198,800.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Гэрэл, цахилгаан	21030100	3,247,400.00	3,257,025.00	-9,625.00	100.30
Түлш, халаалт	21030200	42,151,400.00	42,151,400.00	0.00	100.00
Цэвэр, бохир ус	21030300	6,800,000.00	6,790,375.00	9,625.00	99.86
<b>Хангамж, бараа материалын зардал</b>		<b>23,015,300.00</b>	<b>23,015,300.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Бичиг хэрэг	21040100	4,508,400.00	4,508,400.00	0.00	100.00
Тээвэр, шатахуун	21040200	7,796,200.00	7,796,200.00	0.00	100.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	21040300	3,852,800.00	3,852,800.00	0.00	100.00
Хог хаягдал зайлуулах, мэрэгчдийн ариутгал, хортон устгал,	21040500	325,100.00	325,100.00	0.00	100.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	21040600	6,532,800.00	6,532,800.00	0.00	100.00
<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>		<b>2,434,500.00</b>	<b>2,434,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Урсгал засвар	21060400	2,434,500.00	2,434,500.00	0.00	100.00
<b>Томилолт, зочны зардал</b>		<b>2,474,900.00</b>	<b>2,474,900.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Дотоод албан томилолт	21070200	2,474,900.00	2,474,900.00	0.00	100.00
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>73,399,600.00</b>	<b>73,399,600.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад	21080100	72,211,200.00	72,211,200.00	0.00	100.00

нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж					
Даатгалын үйлчилгээ	21080300	753,000.00	753,000.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн татвар	21080400	102,400.00	102,400.00	0.00	100.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	21080500	22,000.00	22,000.00	0.00	100.00
Газрын төлбөр	21080700	311,000.00	311,000.00	0.00	100.00
<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>		<b>3,426,700.00</b>	<b>3,426,700.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Хичээл үйлдвэрлэлийн дадлага	21090200	3,426,700.00	3,426,700.00	0.00	100.00
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>		<b>25,369,500.00</b>	<b>25,369,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>Бусад урсгал шилжүүлэг</b>		<b>25,369,500.00</b>	<b>25,369,500.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	21320700	25,369,500.00	25,369,500.00	0.00	100.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>1,093,018,000.00</b>	<b>1,092,274,473.22</b>	<b>743,526.78</b>	<b>99.93</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>1,093,018,000.00</b>	<b>1,092,274,473.22</b>	<b>743,526.78</b>	<b>99.93</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13100100	1,093,018,000.00	1,092,274,473.22	743,526.78	99.93

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Бүртгэл ийн дансны код	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		<b>35,000,000.00</b>	<b>35,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>		<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>		<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>		<b>5,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	21080100	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>		<b>30,000,000.00</b>	<b>30,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>Дотоод эх үүсвэрээр</b>		<b>30,000,000.00</b>	<b>30,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Тоног төхөөрөмж	22200100	30,000,000.00	30,000,000.00	0.00	100.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		<b>35,000,000.00</b>	<b>35,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	13100100	0.00	0.00	0.00	100.00
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>		<b>35,000,000.00</b>	<b>35,000,000.00</b>	<b>0.00</b>	<b>100.00</b>
Орон нутгийн төсвөөс	13200100	35,000,000.00	35,000,000.00	0.00	100.00

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Ховд аймгийн Татварын хэлтэс нь эрхэм зорилгын хүрээнд татварын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, татвар төлөгчийг мэдээллээр ханган зөвлөгөө өгөх, сургалт сурталчилгаа явуулах; татварын хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих; улс, орон нутгийн төсвийн татварын орлого бүрдүүлэх; хүний нөөц, төсөв санхүүгийн зохистой бодлогыг хэрэгжүүлэх зэрэг зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

Татварын ерөнхий газрын даргын 2022 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн А/56 тоот тушаалаар Ховд аймгийн Татварын хэлтсийг 49 орон тоотой байхаар баталсан байна.

Татварын хэлтэс нь захиргаа хуулийн тасаг, жижиг татвар төлөгчтэй харилцах тасаг, бичил татвар төлөгчтэй харилцах тасаг, хяналт шалгалтын тасаг гэсэн 4 тасагтайгаар 50 албан хаагчидтайгаар үйл ажиллагаа явуулж байна.

2022 онд тус хэлтэс нь татварын орлогыг бүрдүүлэхэд анхаарч ажиллаж улсын төсөвт 3,893,522.1 мянган төгрөг төвлөрүүлэхээс 4,597,146.4 мянган төгрөг төвлөрүүлж 118.1%, аймгийн төсөвт 5,647,256.0 мянган төгрөг төвлөрүүлэхээс 13,372,397.1 мянган төгрөг төвлөрүүлж 236.8%, сумын төсөвт 16,532,596.8 мянган төгрөг төвлөрүүлэхээс 15,991,114.2 мянган төгрөг төвлөрүүлж 96.7%, нийт дүнгээр төлөвлөгөөний биелэлт 30.3%-иар давуулан биелүүлсэн байна. Сумын төсвийн төлөвлөгөө тасарч байгаа нь мөнгөн хадгаламжийн хүү, хадгаламж эзэмшигчийн тоо буурсан, суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан татвар 2021 оны гүйцэтгэлээр төлөвлөгөөг төлөвлөсөнтэй холбоотой тасарч байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Тус байгууллага нь татварын ерөнхий хууль, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай, хувь хүний орлогын албан татварын тухай, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай, онцгой албан татварын тухай зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд 2022 онд нэмэлт өөрчлөлтүүд орсон байна. 2022 онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд 2 удаагийн, хувь хүний орлогын албан татварын тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт орсныг 2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр байна. Харин эрдэнэсийн сангийн тухай болон зөвшөөрлийн тухай хуулиуд батлагдсантай холбоотойгоор нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуульд 2022 онд 2 удаагийн, согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хууль батлагдсантай холбоотойгоор онцгой албан татварын тухай хуульд 1 удаагийн өөрчлөлт оржээ.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Хэлтсийн даргын тушаалаар байгуулагдсан ажлын хэсэг тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. 2022 онд тус ажлын хэсэг 5 ажлыг төлөвлөн хэрэгжүүлжээ. Татварын ерөнхий газрын дотоод аудит, хяналт, шинжилгээ үнэлгээний газраас тус онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

2022 онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу Ховд аймгийн Татварын хэлтсийн даргын 2022 оны 05 дугаар сарын 27-ны А/17 дугаар

тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, дутагдсан хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Ховд аймгийн Татварын хэлтэс нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Ховд аймгийн Татварын хэлтсийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72.4 сая төгрөгөөр буцуу 4.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	-	-
Авлага	-	-	-
Бараа материал	88,875.1	87,565.8	1,309.3
Үндсэн хөрөнгө	1,492,608.6	1,421,495.9	71,112.7
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,581,483.7</b>	<b>1,509,061.7</b>	<b>72,422.0</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,581,483.7	1,509,061.7	72,422.0
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,581,483.7</b>	<b>1,509,061.7</b>	<b>72,422.0</b>

Дээрх хүснэгтээс харахад Ховд аймгийн Татварын хэлтсийн 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 72,422.0 мянган төгрөгөөр буурсны материаллаг нөлөө нь үндсэн хөрөнгийн данстай холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,465.8 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас 425.4 сая төгрөгөөр бууруулж, 1,040.4 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь 2022 оны төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүй эсвэл өмнөх оны төсвийн гүйцэтгэлд үндэслэснээс шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 52.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,093.0 сая төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1093.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1092.3 сая төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 0.74 сая төгрөгөөр тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Татвар хураалт орлого бүрдүүлэлт / үндсэн үйл ажиллагаа 70205/80101	996,217.3	995,473.8	743.5	99.9
2	Татвар хураалт орлого бүрдүүлэлт / харуул хамгаалалт 70205/80219	21,810.0	21,810.0	0	100
3	Татвар хураалт орлого бүрдүүлэлт / холбоо суваг ашигласны хөлс 70205/80220	49,621.2	49,621.2	0	100
4	Татвар хураалт орлого бүрдүүлэлт / ажил олгогчоос олгох тэтгэмж, дэмжлэг урамшуулал 70205/80802	25,369.5	25,369.5	0	100
<b>ДҮН</b>		<b>1,093,018.0</b>	<b>1,092,274.5</b>	<b>743.5</b>	<b>99.9</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээс 30.0 сая төгрөг, хөшөөт хөгжил сангийн санхүүжилтээр 5.0 сая төгрөг, нийт 35.0 сая төгрөг бүрдүүлж, пос машин, киоск машин, тоног төхөөрөмжийг 30.0 сая төгрөгөөр Төгс шимт оргил ХХК-иас, худалдан авсан. Мөн 5.0 сая төгрөгөөр ажилчдыг Улаанбаатар хотод эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## **4. АУДИТЫН ТАЙЛАН**

### **4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Татварын хэлтсийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аудитор Ц.Бадрал 2023 оны 01 дүгээр сарын 20-ноос 01 дүгээр сарын 24-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 15 албан бичгээр ирүүлсэн байна.

### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,128.0 сая төгрөгөөс 2 хувиар буюу 22.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 18.0 сая төгрөгөөр тогтоосон.

### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

*Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.*

Ховд аймгийн Татварын хэлтэс нь энэ хуулийн 5 дугаар зүйлд заасан тэргүүн дэд, дэд, орлогч дарга, 6 дугаар зүйлд заасан тээврийн хэрэгсэл, 7 дугаар зүйлд заасан албан тасалгаа, 10 дугаар зүйлд заасан цалин хөлс, нэмэгдэлтэй холбоотой заалтууд хамаарахгүй байна.

8 дугаар зүйлд заасан дүрэмт хувцастай холбоотой тус газраас зардал гараагүй бөгөөд Татварын ерөнхий газраас улсын байцаагч нарт 36 ширхэг 6.5 сая төгрөгийн үнэ бүхий дүрэмт хувцас ирж үнэ төлбөргүйгээр бараа материалд бүртгэн авсан байна.

9 дүгээр зүйлд заасан албан томилолтын хувьд тус байгууллага нь 2022 онд 2.4 сая төгрөгийн томилолтын зардлыг 8 албан хаагчид олгосон байна. Энэ нь дарга Улаанбаатар хотод удирдах ажилтны зөвлөгөөнд оролцох, 4 байцаагч хөшөөтийн уурхайд хяналтаар ажиллах, Булган сумын байцаагч нар Ховд аймагт сургалтад хамрагдах зэрэг ажлаар ажилласан байна.

11 дүгээр зүйлд заасан нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн хувьд тэтгэвэрт гарсан 1 улсын байцаагчид 25.4 сая төгрөгийн тэтгэмжийг төрийн албаны тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1-д заасны дагуу олгосон байна.

12 дугаар зүйлд заасан бусад хангамжийн хувьд холбоотой зардал гараагүй байна. Татварын улсын байцаагч нарт сард 0.17 сая төгрөгийн гар утасны зардал олгож байгаа бөгөөд энэ нь Татварын хэлтэс нь өрөө бүрд утасгүйн улмаас байцаагч нарт авлага барагдуулах, тайлан хүлээн авах зэрэгтэй холбоотой татвар төлөгчидтэй холбогдох ажлын зайлшгүй шаардлагаар олгогдсон байна.

13 дугаар зүйлд заасан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, 14 дүгээр зүйлд заасан цахим худалдан авалт, 15 дугаар зүйлд заасан хэмнэлтийн бусад арга хэмжээтэй холбоотой ямар нэгэн зардал гараагүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 159 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа хоцроосон мэдээлэл 15 байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.5 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитаар өгөгдсөн байгууллагын удирдлагын гар утасны төлбөрт төсвөөс зардал гаргасан, хуучин конторын барилгын харуул хамгаалалтын зардалд 1.8 сая төгрөг зарцуулсан зэрэг зөрчлүүдэд зөвлөмж өгсөн байна.

Зөвлөмжийн дагуу Татварын ерөнхий газарт актлуулах санал хүргүүлсэн боловч 2022 онд шийдвэрлэгдээгүй тул харуул хамгаалалтын зардлын төсөв батлагдаж зарцуулагдсан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	-	-	-	-	-
Албан шаардлага	-	-	-	-	-
Зөвлөмж	2	2,368.9	2	2,368.9	100
<b>Нийт дүн</b>	<b>2</b>	<b>2,368.9</b>	<b>2</b>	<b>2,368.9</b>	<b>100</b>

/мянган төгрөгөөр/

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарч үзэх чухал асуудал байхгүй гэж үзлээ.

#### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.7 сая төгрөгийн алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад 0.7 сая төгрөгийн алдааг залруулав.

Үүнд: Хэлтсийн 2022 оны төрийн сангийн харилцах дансны зарцуулаагүй үлдэгдэл болох 0.7 сая төгрөгийг төсвийн нэгдсэн дансанд төвлөрүүлсэн байхад мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэлтэйгээр тайлагнасныг НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн үнэн зөв байх зарчмыг баримтална", НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15 дугаар зүйлийн 15.2-д "Нягтлан бодох бүртгэлийн алдааг гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэж заасны дагуу залруулсан болно.

Аудитаар нийт 0.4 сая төгрөгийн зөрчил<sup>2</sup> илэрснээс 0.4 сая төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

##### 5.1 Зөвлөмж

1. Жолоочийн тооцоотой холбоотой асуудал

###### Илрүүлэлт:

2022 оны 9/29-9/30-ны өдрүүдэд Хөшөөтийн уурхайд Татварын улсын байцаагч нар албан томилолтоор ажилласан байхад жолоочийн тооцооны хуудсанд 9/23-24-ний хооронд ажилласан мэтээр бичсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно, 13.6.Анхан шатны баримтын үнэн зөвийг түүнийг үйлдсэн, зөвшөөрсөн, шалгаж хүлээн авсан ажилтан хариуцна гэснийг зөрчиж байна.

###### Өгсөн зөвлөмж:

Жолоочийн тооцооны хуудсанд автомашины явсан зам километрийг бичихдээ үнэн зөв, бичих, тооцоо бодох, тооцооны хуудсыг хүлээн авахдаа үнэн зөвийг нягтлан шалгаж хүлээн авах.

#### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан	1	743.5			1	743.5	1	743.5				
Дүн	1	743.5			1	743.5	1	743.5				

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөр ийн акт		Албан шаард лага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаал тны тоо	Тоо	Дүн	
Жолоочийн тооцооны хуудсыг алдаатай бичсэн	1	387.6					1	387.6	0	0		0	0
Дүн	1	387.6					1	387.6	0	0		0	0

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:

А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:

Ц.БАДРАЛ